

**“БАГАНУУР ҮЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН ПАРК” ОНӨТҮГ-ЫН
АЛБАН БИЧИГ ШИЙДВЭРЛЭЛТИЙН МЭДЭЭ
/2021.03.23-2021.06.23/**

2021 оны 06 дугаар сарын 23-ны өдөр

Багануур дүүрэг

“Багануур үйлдвэрлэл, технологийн парк” ОНӨТҮГ-т 2021 оны 06 дугаар сарын 21-ний өдрийн байдлаар нийт 102 албан бичиг ирснээс, хариутай бичиг 50, хариугүй бичиг 52 байгаагаас Удирдлагад 4, Захиргааны албанд 80, Үйлдвэрлэл, технологийн албанд 18 албан бичиг хуваарилагдан тус тус шийдвэрлэгдсэн. Мэргэжилтнүүд хариуцсан үйл ажиллагааны чиглэлээр өөрсөддөө хуваарилагдсан албан бичгээ түргэн шуурхай, чанартай шийдвэрлэж байна.

Албан бичгийн эхийг eDoc программаар боловсруулж хэвшсэн. Албан бичгийн шийдвэрлэлтэд eDoc программын модулиудыг (эргэн танилцуулах, эргэн танилцуулах хэлбэр сонгох, хариутай бичгийн хариу сонгох, хамтран шийдвэрлэх) бүрэн ашиглахыг зорьж байна. Хариутай бичгийн шийдвэрлэлт 98.94% (4 бичгийг хариуцсан мэргэжилтнүүд судалж, холбогдох баримт материалыг боловсруулж байна.), нийт ирсэн бичгийн шийдвэрлэлт 100%-тай байна. Шийдвэрлэлтийн дундаж хугацаа 2.66 хоног.


Нийслэлийн Архивын газраас өгсөн чиглэлийн дагуу, Э-токен төхөөрөмж авахад шаардлагатай бичиг баримтуудыг зааврын дагуу бүрдүүлж Газрын дарга болон Бичиг хэрэг, архив, гадаад харилцаа хариуцсан мэргэжилтэн нар Үндэсний Дата төвийн баталгаажуулсан 2 тоон гарын үсгийн гэрчилгээг хүлээн авч үйл ажиллагаанд ашиглаж байна.

Манай байгууллагаас 2021 оны 06 дугаар сарын 22-ны өдрийн байдлаар харилцан холбоотой ажилладаг яам, нийслэл, дүүргийн Засаг даргын Тамгын газар, аж ахуйн нэгж, албан байгууллагууд руу нийт 91 албан бичиг явуулсан байна.

Албан бичгийн шийдвэрлэлтийг 2021 оны 1 ба 2 дугаар улирлын байдлаар харьцуулан графикаар харуулав.

**“БАГАНУУР ҮЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН ПАРК” ОНӨТҮГ-ЫН
АЛБАН БИЧИГ ШИЙДВЭРЛЭЛТ**

/2021 оны 01 дүгээр улирлыг, 2021 оны 02 дугаар улиралтай харьцуулахад/



“БАГАНУУР ҮЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН ПАРК” ОНӨТҮГ-ЫН
АЛБАН БИЧГИЙН ШИЙДВЭРЛЭЛТ

/2021 оны 01 дүгээр улирлыг, 2021 оны 02 дугаар улирлынхтай харьцуулахад,
тоон үзүүлэлтээр/

| № | Нийт ирсэн бичиг | Хариутай бичгийн тоо | Хариугүй бичгийн тоо | Шийдвэрлэлтийн дундаж хугацаа/хоног | Явуулсан бичиг |
|---------------------|------------------|----------------------|----------------------|-------------------------------------|----------------|
| 2021 оны 1-р улирал | 53 | 23 | 30 | 2.18 | 39 |
| 2021 оны 2-р улирал | 51 | 27 | 24 | 3.76 | 52 |

Албан бичгийг хамгийн боломжит богино хугацаанд, чанартай шийдвэрлэхийг зорьж байгаа бөгөөд хариутай бичгийн шийдвэрлэлтийн дундаж хугацаа өмнөх оны мөн үед 3.75 байсан бол энэ онд 2.66 хоног байна.

Албан бичгийн шийдвэрлэлтийн зөрчил, хугацаа хэтэрч хаагдаагүй болон хугацаа хэтэрч хаагдсан албан бичиг байхгүй.

ХЯНАСАН:

“БАГАНУУР ҮЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН ПАРК”
ОНӨТҮГ-ЫН ДАРГА



Ч.ЭЛБЭГСАЙХАН

ТАЙЛАН ГАРГАСАН:

БИЧИГ ХЭРЭГ, АРХИВ, ГАДААД
ХАРИЛЦАА ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН

М.МӨНХДУЛАМ